



# ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Мандах их сургууль

Хөтөлбөрийн нэр: Санхүү

Индекс: D041201

Шинжээчийн баг:

Ахлагч: Б.МӨНХБАЯР

Гишүүд: Н.БАТДЭЛГЭР

С.АЛТАНЦЭЦЭГ

2020.06.03

# Агуулга

## Товчилсон үгийн тайлбар

### I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

### II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

### IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

### V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

### ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

### ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

## Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
БСШУСЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам
ӨҮТ	Өөрийн үнэлгээний тайлан
ДБСБ	Дээд боловсролын сургалтын байгууллага
МИС	Мандах их сургууль
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Мандах их сургууль	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Санхүү	
<b>Индекс</b>	D041201	
<b>Шинжээчид</b>	<p>Багийн ахлагч:</p> <p>1. Б.Мөнхбаяр Санхүү эдийн засгийн их сургуулийн ректор</p> <p>Багийн гишүүд:</p> <p>1. Н.Батдэлгэр Монгол улсын их сургуулийн Бизнесийн сургуулийн дэд профессор</p> <p>2. С.Алтанцэцэг Хөдөө аж ахуйн их сургуулийн Эдийн засаг бизнесийн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга</p>	
<b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>	Г.Даваажаргал	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/</b>
	05/08	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	05/08	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	05/18	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	05/25	Мэргэжилтэн сургууль дээр очиж шинжээч ажиллах бэлтгэлийг хангуулна.
	05/26, 27	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	06/03	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	06/03	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	06/04	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	06/05	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
		Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.

<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-өөс эрхлэн мөрдүүлж буй Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд мөрдөх заавар, журмууд, БСШУ-ны Сайдын 2016 оны 02 сарын 19-ний өдрийн А/53 тушаал, Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайлан, Шинжээчийн үнэлгээний тайлан, холбогдох бусад заавар, эрхийн баримт бичиг, БМИҮЗ-ийн Ажлын албаны захирлын 2020 оны А/51 тушаал.
----------------------------------	--

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Мандах Их сургууль нь 1992 онд байгуулагдсан, байгууллагын магадлан итгэмжлэлийг 4 дэх удаа, Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрөө 3 удаа магадлуулсан бөгөөд 2014 онд Олон улсад магадлан итгэмжлүүлсэн анхны хувийн хэвшлийн сургууль юм.

Сургуулийн эрхэм зорилго болон стратеги зорилтын хүрээнд боловсруулсан Санхүү хөтөлбөр нь Үндэсний болон олон улсын дээд боловсролын стандарт, ажил олгогчдын шалгуур шаардлагыг хангасан, хөрвөх чадвартай, өндөр ёс зүйтэй, санхүүгийн чадварлаг мэргэжилтэн бэлтгэхэд чиглэгдсэн байна.

Сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа хичээлийн хөтөлбөрийн баг нь сонирхогч талуудын болон суралцагчдын эрэлт хэрэгцээ, мөн гадаад дотоодын их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрүүд, ажил мэргэжлийн тодорхойлолт зэргийг харьцуулан дүн шинжилгээ хийсний үндсэн дээр боловсруулж, Хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцүүлдэг. Хөтөлбөрийн дэд хороо нь сайжруулалт хийсний дараагаар Сургалтын хөтөлбөрийн хороо хэлэлцэн дүгнэлт гаргадаг байна. Мөн санхүүгийн чиглэлээр сургалт явуулдаг Монголын томоохон их, дээд сургууль болон олон улсын их, дээд сургуулийн хөтөлбөртэй харьцуулалт судалгааг хийсэн.

Санхүү хөтөлбөрөөр элсэн суралцаж буй оюутнууд, төгсөгчдийн ажил эрхлэлт, аж ахуйн нэгж байгууллагуудын хэрэгцээ, шаардлага зэргээс үндэслэн хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг тооцдог байна.

Мандах Их Сургуулийн сүүлийн 5 жилийн элсэлтийн тоог “Санхүү” хөтөлбөрөөр суралцагчдын орц, гарц үр дүнтэй харьцуулахад нийт элсэлтийн 22 хүртэл хувийг уг хөтөлбөрөөр элсэхийг хүсэгчид байсан байна. Жил бүр уг хөтөлбөрт дунджаар 220 гаран сурагч элсэхээр хүсэлт гаргаснаас 25.8%-ийг элсүүлсэн байна. Сургуулийн хэмжээнд элсэн орж байгаа оюутнуудын 15.2% нь “Санхүү” хөтөлбөрөөр суралцагчид байна. Энэ нь цаашид өсөх хандлагатай гэж үзлээ.

Санхүү хөтөлбөрт элсэгчдийн сүүлийн 5 жилийн орц, гарцын үр дүнг харуулбал:

№	Хичээлийн жил	Элсэхээр бүртгүүлсэн сурагчдын тоо	Элсэлт	Нийт элсэлт	Элсэлт хувиар	Нийт элсэлтэд эзлэх хувь
1	2015-2016	77	22	215	28.6	10.2
2	2016-2017	122	37	441	30.3	8.4
3	2017-2018	172	78	349	45.3	22.3
4	2018-2019	488	61	318	12.5	19.2
5	2019-2020	265	32	199	12.1	16.1
6	<b>Дундаж</b>	<b>224.8</b>	<b>46</b>	<b>304.4</b>	<b>25.8</b>	<b>15.2</b>

Тус хөтөлбөрөөр суралцах анхны элсэлтийг 2015-2016 оны хичээлийн жилд авч, 2 удаагийн төгсөлт хийжээ.

“Санхүү” хөтөлбөрийнхөө хүрээнд ажил олгогч болон төгсөгчдийн төлөөллийг урьж мэргэжлийн багш нар фокус уулзалт хийдэг бөгөөд уг уулзалтаар санхүүгийн байгууллагуудын мэргэжилтнүүдийн хэрэгцээг судлах, сургалтын хөтөлбөрт тавигдах төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, хандлагын талаарх байгууллагуудын санал, санхүүгийн мэргэжлийн хичээлийн хөтөлбөрийн агуулгад зайлшгүй тусгах шаардлагатай сэдэв, арга зүй болон санхүүгийн салбарын өөрчлөлт, шинэчлэлт зэрэг асуудлын талаар хэлэлцэн хөтөлбөрөө сайжруулж ирсэн.

### III. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

#### ШАЛГУУР 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

##### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

##### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн баримт бичиг
- Сургалтын албаны сүүлийн 5 жилийн тайлан, нэмэлт судалгааны тайлангууд

##### Онцлог зүйл/Туршлага:

1. Хөтөлбөрийн төлөвлөлтийг МУ-ын хууль, эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогод тулгуурлан боловсруулсан байна.
2. Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг үндэсний болон олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн сонирхогч талуудын бодит хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн зах зээлийн судалгаанд үндэслэн боловсруулдаг болох нь харагдаж байна.

##### Анхаарах асуудал:

1. Санхүүгийн хөтөлбөрөөр суралцан төгссөн төгсөгчдийн хувь хүний болон мэргэжлийн ур чадвар хөдөлмөрийн зах зээлд ажил олгогчийн бодит хэрэгцээг хэрхэн хангаж буй байдал мөн цаашид эзэмшүүлэх шинэ ур чадваруудын талаар судалгаа хийж, үр дүнд үндэслэн төлөвлөлтийн үйл явцад тусгахад анхаарах;
2. Салбарын чиг хандлагыг тодорхойлох судалгааг тогтмол хийх;

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

##### 1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

##### Илрэл нотолгоо:

- Бакалаврын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө,
- Өөрийн үнэлгээний тайлан
- Бусад нэмэлт мэдээллүүд

##### Онцлог зүйл/Туршлага:

1. Сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсэд суурилсан хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго боловсруулсан байна.

2. Ингэхдээ үндэсний болон олон улсын дээд боловсролын стандартыг хангахад чиглэсэн зорилгыг судалгаанд үндэслэн боловсруулжээ.

**Анхаарах асуудал:**

1. Дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд сургалт судалгааны дэвшилтэт технологи, аргыг богино хугацаанд нэвтрүүлэх шаардлага тулгарч болзошгүйг анхаарах;

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Бакалаврын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө,
- Өөрийн үнэлгээний тайлан
- Бусад нэмэлт мэдээллүүд

**Онцлог зүйл/Туршлага:**

2. МУ-ын хууль, салбарын бодлогын баримт бичгүүд болон олон улсын хөгжлийн чиг хандлагыг судлан, тогтмол сайжруулах ажил хийгддэг нь харагдаж байна.
3. Сургалтын агуулга, арга зүй, үнэлгээг олон улсын болон дотоодын их дээд сургуулиудын ижил төрлийн хөтөлбөрүүдтэй харьцуулан судлан, туршлага солилцдог онцлог байна.
4. Хөтөлбөрийн баримт бичиг, хичээлийн төлөвлөгөө стандартын дагуу боловсруулагдсан нь холбогдох баримт бичгээр нотлогдож байна.

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

**1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **ШАЛГУУР 2. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Тэнхимийн тайлан
- Санхүүгийн хөтөлбөрийн цогц баримт бичиг
- Хөтөлбөрийн дэд хороо болон хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл

### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Сургалтын агуулга, түүний шинэчлэл нь суралцагчийн эзэмших цогц чадамж, онол практикийн зохистой харьцааг хангасан байна.
2. Хөтөлбөрийн агуулга нь суралцагчид сонгон суралцах боломжийг олгосон, агуулгын шинэчлэл тасралтгүй хийгдэж байгааг нотлох баримтуудаас харагдаж байна.
3. Санхүүгийн бакалаврын хөтөлбөрөөр суралцагчдын суурь мэдлэг, чадвар, хандлагыг онол практикийн зохистой харьцаагаар тодорхойлж мөрдөн ажиллаж байна.

### **Зөвлөмж:**

1. Хөтөлбөрийн агуулгын шинэчлэлийг тасралтгүй сайжруулах зорилгоор оролцогч талуудын санал, хэрэгцээг тогтмол судлан, сонголтоор эзэмших хичээлийн тоог нэмэгдүүлэх.

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

## **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Тэнхимийн тайлан
- Санхүүгийн хөтөлбөрийн цогц баримт бичиг
- Хөтөлбөрийн дэд хороо болон Сургалтын хөтөлбөрийн хорооны хурлын холбогдох тэмдэглэлүүд

### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Хөтөлбөрийн сургалтын арга зүй нь багшлахуйн, суралцахуйн арга зүйд суурилсан, суралцагч төвтэй дэвшилтэт техник, технологийг ашиглаж буй сайн туршлага байна.
2. Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжийг олгоход чиглэсэн байна.
3. Арга зүйн шинэлэг арга хэрэгслийг ашиглах оролдлого хийж байгаа нь нотлох баримтаар харагдаж байна.
4. Онцлог сургалтын арга зүйг ашиглаж байна.

### **Анхаарах асуудал:**

1. Арга зүйг хөгжүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулах түгээх;
2. Багийн багшлах арга зүйг хөгжүүлэх, нэмэгдүүлэх;



### **Зөвлөмж:**

1. Хөтөлбөрийн онцлог, ажил олгогчдын хэрэгцээнд тулгуурлан ажлын байрны шаардлагаар хөрвөх боломжийг анхаарч судалгаа, шинжилгээ хийх.

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

### **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Оюутны мэдлэг, чадварыг үнэлэх журам
- Тэнхимийн тайлан
- Санхүүгийн хөтөлбөрийн цогц баримт бичиг
- Хөтөлбөрийн дэд хороо болон Сургалтын хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл

#### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Оюутны мэдлэг, чадварыг үнэлэх журмын дагуу суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж хэвшсэн байна.
2. Үнэлгээний арга зүйг хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн тасралтгүй сайжруулахыг эрмэлздэг.

#### **Анхаарах асуудал:**

1. Практик хэрэглээг нэмэгдүүлэхэд анхаарах.

### **Зөвлөмж:**

2. Суралцагчдын мэдлэг чадварыг үнэлж байгаа арга туршлагаа улам боловсронгуй болгож, суралцахуйн хүрэх үр дүн (learning outcome)-г сургалтын агуулгаар дамжуулан хэрхэн үнэлж болохыг тодорхойлон хэрэгжүүлэх.

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **ШАЛГУУР 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- 10,600 м<sup>2</sup> талбай бүхий хичээлийн шинэ байрыг ашиглалтад оруулснаар сургуулийн орчин, нөөц сайжирсан байна (Студи, музей, оффис, буфет, старт-апын дундын оффис, спорт заал гэх мэт)
- ХБИ-д зориулсан ариун цэврийн өрөө, цахилгаан шат, тэргэнцэртэй явах шатыг иж бүрэн тохижуулсан байна.
- Бүх анги танхимыг проектор, самбараар иж бүрэн тоногловсон байна.

### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Олон улсын стандартад нийцсэн 250 хүний спорт заалтай.
2. Шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоногловсон хичээлийн анги танхимуудтай.
3. Оюутан залуусын гарааны бизнесийг дэмжих дундын оффисыг бий болгосон.
4. Сургалтын үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилтын хүрээнд тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчин ашиглах нөхцөл бүрдсэн.

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын багц материал боловсруулах удирдамж /MU-GD-3:2017CC/
- Хичээлийн хөтөлбөр боловсруулах журам /MU-PR-10:2016CC/
- Сургалтын хэрэглэгдэхүүнд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ тасралтгүй өссөн байна (хүснэгт 3.6)
- Лабораторийн тоног төхөөрөмжийн жагсаалт, ашиглаж буй программ хангамж (Хүснэгт 3.7, хүснэгт 3.11) -тай байна.

### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Багш нар цахим хичээлийн агуулгыг идэвхтэй боловсруулж, хэрэглэж байна.
2. Лекц семинарын анги танхмыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоногловсон, сургалтын таатай орчныг бүрдүүлсэн.
3. Сургалтын орчныг сайжруулах чиглэлээр холбогдох судалгаа, шинжилгээг хийж, сайжруулахыг зорьдог нь ажиглагдсан.

### **Анхаарах асуудал:**

1. Цахим сургалтыг зохион байгуулахдаа хэт олон төрлийн платформ ашиглаж байна. Ингэснээр интернетийн орчинд суралцах суралцагчдад хэт их ачаалал үүсэх, хичээл зааж буй багшаас хамааран оюутнууд төрөл бүрийн программ хангамж, платформ ашиглах шаардлага үүсэж болзошгүйг цаашид анхаарах;
2. Сурах бичгийн жагсаалтыг гаргахдаа ерөнхий эрдмийн хичээлийн сурах бичгийг оруулаагүйг анхаарах. (Хавсралт №1-ээр харуулав гэсэн байна.

Хуудас 60, хавсралт №1-ээр харуулав гэсэн байх боловч хавсралт байхгүй байна)

**Зөвлөмж:**

1. Цахим сургалтыг зохион байгуулах платформыг нэгтгэх боломжийг эрэлхийлэх.

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан байна.**

**3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Иж бүрэн компьютерын лаборатори
- Номын сангаас нэвтэрч болох цахим эх сурвалжуудыг жагсаалт (JSTOR, EBSCO гэх мэт)

**Онцлог зүйл/Туршлага:**

1. Цахим номын сангийн эрдэм шинжилгээний лабораторийг бий болгож, суралцагчид бие даан суралцах, судалгааг хийх орчин нөхцөлийг бий болгосон.

**Анхаарах асуудал:**

1. Үндсэн сурах бичиг, гарын авлагын жагсаалтыг ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлээр ангилан тодруулах. (Сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа байхгүй)

**Зөвлөмж:**

1. Ном сурах бичгийн ашиглалт, хүрэлцээ хангамжийн судалгаа мониторинг хийх;
2. Мэргэжлийн хичээлүүдийн үндсэн сурах бичгийн жагсаалтыг нэгтгэж суралцаж буй оюутны хэмжээнд хүрэлцээтэй байгаа эсэхийг жил бүр судлан үзэж, хэрэгцээтэй сурах бичгийн фондыг бий болгох тал дээр төлөвлөж ажиллах;

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

**ШАЛГУУР 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

#### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- Хичээлийн хөтөлбөрийн багийн хурлын тэмдэглэлүүд
- Эрдмийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, захирлын тушаал
- Сургалтын өдөр тутмын үйл ажиллагаа шуурхай удирдлагаар хангах CLOUD мэдээллийн системийг нэвтрүүлж эхэлсэн байна.
- 2011 онд мониторингийн орон тоог бий болгож, 2017 онд чанарын удирдлагын олон улсын стандарт ISO9001:2015 стандартыг нэвтрүүлж, чанарын үнэлгээний хороог ажиллуулж байна.

##### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Хичээлийн хөтөлбөрийн багуудын үйл ажиллагаа жигдэрсэн, хичээлийн хөтөлбөрийн сайжруулалтыг хичээлийн хөтөлбөрийн багаар тасралтгүй гүйцэтгэдэг.
2. ISO9001:2015 стандартыг нэвтрүүлж, чанарын үнэлгээний хороог ажиллуулж байна.

##### **Анхаарах асуудал:**

1. Төгсөгч, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн нэгтгэлийг хуудас 69-д тусгасан байгаа боловч тухайн судалгааны үр дүн нь Мандах их сургуулийн хэмжээнд хийгдсэн судалгааны үр дүн байгааг анхаарах.

##### **Зөвлөмж:**

1. Өөрийн үнэлгээний тайланд, хичээлийн хөтөлбөрийн хороо, тэнхимийн хөтөлбөрийн хороо, тэнхим, сургалтын хөтөлбөрийн хороо, эрдмийн зөвлөлийн харилцан хамаарал, эрх мэдлийн хуваарилалтыг тодорхой тайлагнах;
2. Сургалтын хөтөлбөрийн хороо болон тэнхимийн харилцан хамаарал, уялдааг сайжруулах;

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан**

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Хамтран ажилладаг байгууллагуудыг жагсаалт;
- Хамтран ажилладаг байгууллагуудаас зохион байгуулдаг уралдаан, тэмцээнд оролцсон амжилтууд;
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн тайлан

### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төвийг ажиллуулж, тайлан мэдээлэл гаргадаг.
2. Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төвийг ажиллуулдаг.

### **Анхаарах асуудал:**

1. Шалгуур 4.2 хэсгийг Санхүү хөтөлбөрийн багш, суралцагчийн оролцсон төсөл, хөтөлбөрийн мэдээллээр баяжуулах, өөрчлөх.
2. Мандах их сургуулийн хэмжээнд хийгдсэн хамтын ажиллагааны гэрээнүүд нь сургуулийн цахим хуудсанд (<http://mandakh.edu.mn/news/31>) байгаа хэдий ч Санхүү хөтөлбөрийн багш, суралцагчдын хамрагдсан байдал тодорхойгүй байна.

### **Зөвлөмж:**

1. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээтэй холбоотой тайлан бичигдсэн агуулгыг Санхүү хөтөлбөр (эсвэл Эдийн засаг, бизнесийн удирдлагын тэнхим)-ийн хүрээнд хийгдсэн ажил, багш, оюутан гэсэн ангиллаар өөрчлөх; /Энэ хэсэгт голчлон Мандах их сургуулийн хүрээнд хийгддэг ажлуудыг жагсаан бичсэн байна./
2. Төсөл, хөтөлбөрт хамрагдах оюутны оролцоо, тоог нэмэгдүүлэх, баримтаар баталгаажуулан тайланд тусгах;

### **Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг хэсэгчлэн хангасан**

#### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- 2014-2019 оны орлогын тайлан (тайлангийн 77-р хуудас)
- Оюутны үйлчилгээнд зарцуулсан мөнгөн дүн (Сургуулийн хэмжээнд)

### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.
2. Багш, ажилтныг хөгжүүлэх, тэдгээрийн мэргэжлийн хөгжлийг хангахад анхаарч ажилладаг нь ажиглагдаж байна.

### **Анхаарах асуудал:**

1. Хуудас 78, хүснэгт 4.6-д нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцооны аргачлалыг тодруулах, ойлгомжтой болгох.
2. Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тэнхим, сургуульд оруулж буй орлого, зардлын тооцоог хийх

### **Зөвлөмж:**

1. Төсөл, хөтөлбөрт хамрагдах оюутны оролцоо, тоог нэмэгдүүлэх, баримтаар баталгаажуулан тайланд тусгах;

2. Хөтөлбөрөөр суралцагчдад дэмжлэг үзүүлэх санхүүгийн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх;

### **Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан**

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Мандах их сургуулийн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн тоо
- Зар сурталчилгаа, маркетингийн зардлын дүн (хүснэгт 4.9)

##### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Төгсөгчдийг мөшгих судалгааг хийж, оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр анхаарч ажиллаж байна.
2. Хөтөлбөрийн таниулах, сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулдаг нь холбогдох нотлох баримтаар харагдаж байна.

##### **Анхаарах асуудал:**

1. Тайлангийн тоон мэдээллүүд зөрж байгааг анхаарах. (Хүснэгт 4.7, хүснэгт 1.1).
2. Хөтөлбөрийн маркетингийг сайжруулахад чиглэсэн судалгааг тогтмол хийж, үр дүнгээр нь тодорхой төлөвлөгөөтэй ажил зохион байгуулах.

##### **Зөвлөмж:**

1. Маркетингийн баг ажиллуулж, өөрийн үйл ажиллагааг үнэлдэг байх.

### **Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн нээлттэй ил тод байдлыг хангах нэгэн хэрэгсэл нь тус сургуулийн цахим хаяг болох <http://mandakh.edu.mn/> хаяг болон Эдийн засаг, бизнесийн тэнхимийн (<http://mandakh.edu.mn/tankhim/70>) хаяг байна. Тус хаягуудаар нэвтэрч хичээл заах багшийн талаар мэдээлэл авах боломжтой байна.
- Санхүү хөтөлбөрийн ерөнхий мэдээллийг <http://mandakh.edu.mn/news/81/single/77> холбоосоор нэвтэрч харж болж байна.
- Сургуулиас эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлүүд

##### **Анхаарах асуудал:**

1. Мандах их сургуулийн цахим хуудсан дахь Эдийн засаг, бизнесийн тэнхимийн холбоос (<http://mandakh.edu.mn/tankhim/70>) -оор нэвтрэн ороход тухайн тэнхим нь Санхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэгч гэсэн тодорхой мэдээлэл тусгах.

Одоо (2020 оны 6 сар) байгаа мэдээллээр “Бизнес удирдлагын болон нийгэм хүмүүнлэгийн чиглэлийн хичээлүүдийг заадаг. Үүнд: хичээлүүдийн хагсаалт” -ыг тусгасан байна.

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

**4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **ШАЛГУУР 5. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Удирдах зөвлөлийн тогтоол
- Элсэлтийн журам
- Элсэлтийн үйл ажиллагааны тайлан
- Өөрийн үнэлгээний тайлан

**Онцлог зүйл/Туршлага:**

1. Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуурыг БСШУСЯ болон хөтөлбөрийн онцлогт нийцүүлэн боловсруулсан МИС-ийн элсэлтийн журмын дагуу суралцагчийг сонгох, элсүүлэх ажлыг зохион байгуулан хэвшсэн байна.
2. Элсэгчдийг сонгон шалгаруулах ажлыг сургуулийн элсэлтийн бодлого, журам, хяналтын тоонд багтаан сонгон шалгаруулдаг.
3. Зөвлөн туслах үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн баримтжуулалтыг сайжруулдаг нь харагдаж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Захирлын тушаалууд
- Тэнхимийн тайлан
- Санхүүгийн тайлан
- Сургалтын албаны тайлан
- Өөрийн үнэлгээний тайлан

**Онцлог зүйл/Туршлага:**

1. Зөвлөн туслах үйлчилгээ нь оюутан суралцагчдад хүртээмжтэй байгаа нь оюутан суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны дүнгээс харагдаж байна.
2. Оюутныг хөгжүүлэхэд чиглэсэн үйлчилгээг төрөлжүүлсэн, тогтмол зохион байгуулдаг.

**Зөвлөмж:**

1. Сайн дурын үйл ажиллагааны хүрээг нэмэгдүүлэх хөтөлбөрийн эцсийн зорилготой уялдуулах;
2. Зорилго, хандлага, ёс зүй гэх мэт ур чадваруудтай холбох;

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

**5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Нэмэлт судалгааны мэдээлэл

**Онцлог зүйл/Туршлага:**

1. Оюутан суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг тогтолцоо бүрдсэн талаар тайланд маш тодорхой тусгасан байна.

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

**5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- “Оюутны шилжилт хөдөлгөөний журам” дагуу хийсэн нэмэлт судалгаа мэдээлэл

**Онцлог зүйл/Туршлага:**

1. Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг “Оюутны шилжилт хөдөлгөөний журам”-ын хүрээнд шийддэг байна. Кредит хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх зэргийг дээрх холбогдох журмын дагуу шийдвэрлэдэг талаар тайланд тусгасан байна.

**Зөвлөмж:**

1. Дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагуудад судалсан кредитийг харилцан хүлээн зөвшөөрдөг, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх тухай холбогдох харилцааг шийдвэрлэх агуулыг журамд тусгах.



## Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.

### 5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

#### Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Дипломын загвар, төгсөлт хийх тухай гаргасан тушаал, шийдвэрүүд

#### Онцлог зүйл/Туршлага:

1. Төгсөлтийн баримт бичгийн загвар болон төгсөлтийн баримт бичгийг олгох журмын хэрэгжилтийн байдал нь Боловсролын тухай, Дээд боловсролын тухай хууль, БСШУСЯ-наас батлан гарагсан загвар стандарт, журмуудад бүрэн нийцсэн байна.
2. МИС-ийн төгсөгчидэд олгож буй төгсөлтийн баримт бичигүүд нь төгсөгчдийн эзэмшсэн мэдлэг, ур чадварын үнэлгээ, хөтөлбөрийн агуулга, үр дүн, боловсролын зэргийг тусгасан байна.

## Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.

### 5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

## ШАЛГУУР 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

### 6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### Илрэл нотолгоо:

- Хүний нөөцийн бодлогын хэрэгжиж буй баримт бичгүүд: хөдөлмөрийн хууль, ёс зүйн дүрэм, дотоод журам, гэрээ, хүний нөөцийн хөгжлийн дэмжих төлөвлөгөө, багшийн хөдөлмөрийг үнэлэх журам зэргийг хэрэгжүүлдэг байна.
- 2015-2019 онд багшийн сонгон шалгаруулалт, хүний нөөцийн хөгжлийг дэмжих, чадваржуулах талаар холбогдох журмыг шинэчилж, хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллаж байна.
- Нийт багш нарын тоонд докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин 2015-2019 онд 15,9-32 хувьд хүрсэн. Нийт 21 багш докторантурт суралцаж байна. Энд санхүүгийн мэргэшүүлэх хичээл заадаг багш нарын хувьд дээрх тоон үзүүлэлт тайланд тусгаагүй байв.
- Нэг багшид ноогдох оюутны тоо 18,5 буюу улсын дунджаас /23,6/ доогуур үзүүлэлттэй.
- Багшийн албан тушаалын зэрэглэлийг дээд боловсролын хуулинд заасан ангиллын дагуу дадлагажигч, багш, ахлах, дэд профессор, профессорын гэсэн ангиллаар мөрдүүлдэг.

- Багшийн албан тушаалын зэрэглэлийг хэрхэн тогтоодог, зэрэглэл тогтоох ажлыг хэрхэн зохион байгуулдаг талаар тайланд тусгаагүй байсан хэдий ч энэ талаар сургууль дээр ажиллах явцдаа тодруулсан. Багшийн зэрэглэл тогтоох тусгай журамгүй боловч дотоод журам, хүний нөөцийн хөгжлийн дэмжих төлөвлөгөө, багшийн хөдөлмөрийг үнэлэх журам зэрэгт зарим зүйл болгон тусгасан байна.
- Багш нарт олгосон урамшууллын судалгаатай байна.
- Багшийн цагийн ноогдол, хуваарилалт, ачааллын судалгааг тайланд тусгаагүй боловч уулзалтын үеэр тодруулж хариулт авсан. Ачаалал их байдаг. Багш 1,5 дахин ачаалалтай ажилладаг.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Докторын зэрэгтэй багш нарын тоо сүүлийн 4 жилд 15-32 хувь болж 2 дахин өссөн.

#### **Анхаарах асуудал:**

1. Хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд хэрхэн шинжилгээ, дүгнэлт өгдөг талаар тайланд дурдаагүй байсан.

#### **Зөвлөмж:**

1. Хөтөлбөрийн хүний нөөцийн бодлого, сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилтийн цогц баримт бичиг боловсруулах;
2. Багшийн хөгжлийн иж бүрэн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх. Ингэхдээ хөтөлбөрийн хэрэгжилтэд тасралтгүй сайжруулдаг байх;

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

### **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Багш, ажилтны хөгжлийн хороо байгуулж (2015), хүний нөөцийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө боловсруулж ажилладаг байна. Хүний нөөцийн цогц бодлогын хүрээнд сонгон шалгаруулалт, хөгжүүлэлтийн хүрээнд түлхүү анхаарч ажил зохион байгуулдаг бөгөөд хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд шинжилгээ, дүгнэлт өгч ажилладаг.
- Багшийн суралцах, мэргэжил дээшлүүлэх сургалтын хэрэгцээг өөрсдөөс нь санал авдаг, нөгөө талаас БАХХ сургуулийн стратеги төлөвлөгөө, тэнхим нэгжүүдийн ажлын төлөвлөгөө, оюутны сэтгэл ханамжийн судалгаа зэрэгт үндэслэн төлөвлөдөг.
- БАХХ хийсэн ажил нь судалгаа авч, сургалт, заах арга зүй, мэргэжил хувь хүнийг хөгжлийг дэмжих чиглэлээр сургалтууд зохион байгуулсан. Сүүлийн 2 хичээлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэсэн байна.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Хүний нөөцийн цогц бодлогын хүрээнд сонгон шалгаруулалт, хөгжүүлэлтийн хүрээнд түлхүү анхаарч нэлээд ажил зохион байгуулдаг байна.

**Анхаарах асуудал:**

1. Хүний нөөцийн хөгжлийг дэмжих төлөвлөгөөнд сайжруулалт хийж, иж бүрэн хөтөлбөр боловсруулахад анхаарах.

**Зөвлөмж:**

1. Багшийн хөгжлийн хөтөлбөрийг иж бүрнээр нь боловсруулж, түүний хэрэгжилтэд үнэлэлт өгдөг, сайжруулалт хийдэг арга зүйтэй байх.

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

**6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- 2017-2019 оны эрдэм шинжилгээний ажлын тайлангийн мэдээнээс үзэхэд багш нарын оролцож хэрэгжүүлсэн төсөл, захиалгат ажлын бүтцэд байгууллагын захиалгат сургалт 45-47 хувь, байгууллагад зөвлөх үйлчилгээ 40 хувь, бизнес төсөл 10 хувь, захиалгат судалгааны ажил 3 хувьтай байна.
- Эдгээр ажилд багш нарын оролцоо харилцан адилгүй бөгөөд захиалгат сургалт, байгууллагад зөвлөх үйлчилгээний ажилд багш нарын оролцоо 50 хувь, бизнесийн төсөл ба захиалгат судалгааны төсөлд 3-4 хувь нь оролцсон байна.
- Багш нарын бүтээлийн патентын эрхийг сүүлийн 5 жилд нэг багшийн 2 бүтээл хүртсэн байна. Багш нарын туурвисан сурах бичиг, гарын авлагуудын ихэнх ISBN дугаартай байна. Харин Зохиогчийн эрхийн гэрчилгээтэй бүтээлүүдийн судалгаа байхгүй байна.
- Багш нарын бүтээлийн тоо, олон улсын түвшинд ба дотоодод хэлэлцүүлсэн илтгэл, өгүүллийн тоо мэдээлэл, эрдэм шинжилгээний ажилд зарцуулсан зардлын мэдээ судалгааг тайландаа тайлагнасан байна.

**Онцлог зүйл/Туршлага:**

1. Байгууллагын захиалгат сургалт, зөвлөх үйлчилгээ зэрэгт багш нарын 50 орчим хувь оролцдог байна.

**Анхаарах асуудал:**

1. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэл, хүрсэн түвшний мэдээллийг тайланд тусгаагүй боловч зарим талаар тодруулга, асуултаар хариулт авлаа.
2. Захиалгат төсөл, судалгаа, гэрээт ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга шинэчлэгдэн хөгжсөн байдлыг илтгэх нотолгоо тайлбар хангалттай бус байсан.

**Зөвлөмж:**

1. Эрдэм шинжилгээний мэдээллийн сан ашиглалтын өнөөгийн байдал ямар түвшинд байгаа, бүтээлээ олон улсын нэр хүндтэй сэтгүүлд хүлээн зөвшөөрүүлэх ажлын эхлэлийг хэрхэн гүйцэтгэж буй, өгүүллийн гадаад дотоодод эшлэгдсэн байдлын нотолгоо, тандалт судалгааг хийж сургуулийн ЭШ-ний тайланд тусгаж байх;

2. Бизнесийн төсөл ба захиалгат судалгааны төсөлд оролцох, эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээ олон улсын хянан магадалгаа хийгддэг сэтгүүлд хүлээн зөвшөөрүүлэх зэрэг ажилд багш нарын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах;

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

#### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Багш өөрийн үнэлгээний тайлангаа хагас жил тутам бэлтгэж, тэнхимээр хэлэлцүүлснээр тэнхмийн нэгтгэлийг сургуулийн нэгдсэн тайлангийн хуралд танилцуулдаг. Суралцагчдаас хөтөлбөрийн хэрэгжилт ба багшийн үйл ажиллагааг /сургалт, заах арга зүйн/ үнэлүүлэх ажил тогтмолжсон. Багшийн өөрийн үнэлгээний тайлан, оюутны үнэлгээний дүнд үндэслэн багшийн үр дүнгийн нэмэгдэл, урамшуулал олгодог.
- Сүүлийн 5 жилд оюутнуудаас нийт багш нарын сургалт, заах арга зүйн талаар сэтгэл ханамжийн судалгааны дүнг тайланд тусгасан байна. Харин Санхүүгийн хөтөлбөрийн багшийн хөндлөнгийн үнэлгээ, сэтгэл ханамжийн судалгааны нарийвчилсан дүн шинжилгээ харагдсангүй.
- Багшийн үйл ажиллагааны баримт бичигт тавигдах шаардлага, бүрдүүлэлт, хөтлөлт, гүйцэтгэлийн чанарын хяналтын чиглэлээр хийдэг ажлууд дурдагдаагүй байсан боловч тодруулга мэдээлэл авлаа.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Багшийн өөрийн үнэлгээний тайлан, оюутны үнэлгээний дүнд үндэслэн багшийн үр дүнгийн нэмэгдэл, урамшуулал олгодог.

#### **Анхаарах асуудал:**

1. Тухайн магадлан итгэмжлүүлж буй санхүүгийн хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээ, сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг тусад нь тайлагнаж байх.

#### **Зөвлөмж:**

1. Багшийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг сургалт, заах арга зүйн, эрдэм шинжилгээ, инновацын, мэргэжлийн нийгмийн үйл ажиллагаа, багшийн ур чадвар, ахиц дэвшлийн үйл ажиллагааны төрлөөр, багшийн чадамжийн үнэлгээг /мэдлэгийн, мэргэжлийн, судалгааны, хувь хүний гэсэн чиглэлээр тодорхойлж, ангилж боловсруулах;

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

**6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **ШАЛГУУР 7. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

## **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

### **Илрэл нотолгоо:**

- 2011 онд хөтөлбөрийн мониторинг судалгаа хийх үүрэгтэй хяналт шинжилгээ, үнэлгээний арга зүйч орон тооны ажилтантай болсон.
- 2014 онд сургалтын хөтөлбөрийн хороо, мэргэжлийн тэнхимийн дэд хороодыг байгуулж чанарын баталгаажуулалтын ажлыг гүйцэтгэж байна.
- Тус сургуульд 2017 оноос дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэх буюу хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэгтэй “Чанарын үнэлгээний хороо” –г (орон тооны бус) байгуулан ажиллаж байна.
- 2017 онд дотоод чанарын баталгаажуулалтын Олон улсын стандартыг нэвтрүүлэн, ISO 9001:2015 стандарт нэвтрүүлсэн байгууллагын гэрчилгээ хүлээн авсан байна.
- Сургалтын хөтөлбөрийн чанарыг тодорхойлох үзүүлэлтүүдийг боловсруулан мониторинг судалгаанд ашиглаж байна.
- Хөтөлбөрийн үнэлгээ, дотоод чанарын баталгаажуулалтын ажилд оюутан, багш ажилтан, төгсөгч, ажил олгогч, дадлагажуулагч, шалгалтын комисс, удирдлага, БАХХ, чанарын үнэлгээний хороо зэрэг оролцогч талуудыг хамруулан ажиллаж байна.
- Хөтөлбөрт өгөх оролцогч талуудын үнэлгээг нэлээд олон төрлийн арга хэрэгсэл бүхий асуулга ашиглаж гүйцэтгэж байна. Үүнд:
- Хичээл бүрд өгсөн оюутны сэтгэл ханамжийн судалгаа, сургалтын хөтөлбөрийн болон үйл ажиллагааны, төгсөгч ба ажил олгогчийн, багш ажилтны сэтгэл ханамжийн үнэлгээ, багшийн хичээлд суусан тэмдэглэл, зөвлөмжид хийсэн шинжилгээ, төгсөгчдийг мөшгөх судалгаа, ажил олгогчидтой хийх уулзалт, ярилцлага, оюутны дадлагажуулагч нарын үнэлгээ, оюутны чадамжийн шалгалтын үнэлгээ, алба нэгжүүдийн үнэлгээ, зохион байгуулсан ажлын гарц, үр дүнгийн тайлан, дотоод аудит, удирдлагын шинжилгээ зэрэг олон төрлүүдтэй байна.
- Дээрх судалгааны дүнг үндэслэн тодорхой ажлууд зохион байгуулан ажилласан.
- Англи хэлний хичээлийн кредитийг нэмэгдүүлсэн. Мэргэжлийн ба санхүүгийн англи хэл гэж салган заах болсон. Санхүүгийн POWER BI програмыг сургалтад ашиглах болсон. Мөн SPSS, E-Views програмаар боловсруулалт хийх ажлыг бие даалтын хөтөлбөрт оруулсан. Ажил олгогчтой түншлэлийн гэрээ байгуулж, дадлагын хөтөлбөрийн агуулгыг шинэчлэн, үйлдвэрлэлийн кейс дадлага хийлгэх болсон. Оюутны төгсөлтийн ажил бичиж хамгаалах боломжийг нэмэгдүүлсэн.

### **Онцлог зүйл/Туршлага:**

1. 2017 онд дотоод чанарын баталгаажуулалтын Олон улсын стандартыг нэвтрүүлэн, ISO 9001:2015 стандарт нэвтрүүлсэн байгууллагын гэрчилгээ хүлээн авсан байна.
2. Сургалтын хөтөлбөрийн чанарыг тодорхойлох үзүүлэлтүүдийг боловсруулан мониторинг судалгаанд ашиглаж байна.

**Анхаарах асуудал:**

1. Магадлан итгэмжлүүлж буй санхүүгийн хөтөлбөрийн чанарыг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах нь чухал.

**Зөвлөмж:**

1. Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын загвар боловсруулах.

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

**7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

**Илрэл нотолгоо:**

- Санхүүгийн хөтөлбөрөөр 1 удаа төгсөлт хийсэн ажил эрхлэлтийн хувь 70 хувь байна гэж тайланд тусгасан. Мөн төгсөгч, ажил олгогчдын төлөөлөлтэй уулзалтын үеэр асуултандаа хариулт авсан.
- Хөтөлбөрийн үр дүнг “ажил олгогчоос ажлын байрны саналыг тогтмол ирүүлдэг” гэж тэмдэглэсэн байна.

**Анхаарах асуудал:**

1. Тайланд санхүүгийн мэргэжлийн хөтөлбөрөөр төгсөгчийн чадамжийг тодорхойлоогүй байна.
2. Хөтөлбөрийн үр дүнгийн судалгааг бүрэн тайлагнаагүй байна.

**Зөвлөмж:**

- Холбогдох сургалтын баримт бичгүүдэд санхүүгийн мэргэжлийн хөтөлбөрөөр төгсөгчийн чадамжийг тодорхойлсон “Төгсөгчийн загвар”-ыг боловсруулах.

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

**7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Байгууллагын болон НББ-ийн хөтөлбөрөө дотоодод болон олон улсад магадлан итгэмжлүүлсэн туршлагад үндэслэн Санхүүгийн хөтөлбөрөө итгэмжлүүлж байна. Мандах их сургуулийн бакалаврын хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын хөтөлбөр, оролцогч талуудаас авах судалгааны журмын дагуу 2019 оны төгсөгчдийн сэтгэл ханамж, хөтөлбөрийн үнэлгээ, ажил олгогчдын үнэлгээний судалгааг 2020 оны 05 сард хийхээр төлөвлөсөн байна.
- Санхүүгийн хөтөлбөрөөр 2019 онд төгсөгчдийн 50 хувь нь мэргэжлээрээ, 20 хувь нь нягтлан бодогчоор ажиллаж буй нь мэргэжил, ур чадвар, хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурь, ажлын байрны нийцэл зэрэг сайн байна гэж тайланд дүгнэсэн байна. Цаашдын олон удаагийн төгсөлтийн үр дүн, ажил эрхлэлтийн түвшин дээрх дүгнэлтийг баталгаажуулах ёстой бөгөөд үүнд хүрэхийн тулд хөтөлбөрийн оролцогч талуудын ажлын чанарын үзүүлэлт чухал гэж шинжээчийн зүгээс үзэж байна.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

1. НББ-ийн бакалаврын хөтөлбөр нь дотоодын магадлан итгэмжлэлд 2005 оноос хойш 3 удаа, 2014 онд олон улсад магадлан итгэмжлүүлсэн.
2. Санхүүгийн хөтөлбөр нь 2 удаагийн /2019, 2020/ төгсөлт хийсэн байна.

#### **Анхаарах асуудал:**

1. Санхүүгийн хөтөлбөрт мэргэжлийн холбоодоор хөндлөнгийн үнэлгээ хийлгээгүй байна.

#### **Зөвлөмж:**

1. Хөтөлбөрийн чанарын болон үр нөлөөний үнэлгээ, чанарын баталгаажуулалтын үйл явцад оролцогч талуудын үүргийг нэмэгдүүлэхэд мэргэжлийн байгууллагуудын үнэлгээ ач холбогдолтой тул энэ хөтөлбөрт мэргэжлийн холбоодоор үнэлгээ хийлгэх;
2. Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувийг тодорхойлсон судалгаа тасралтгүй хийх;
3. Хөтөлбөрийн чанарын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх, чанарын баталгаажуулалт хийх, хөтөлбөрийг удирдлага зохион байгуулалтаар хангах, оролцогч талуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх, хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэх, сайжруулах зорилгоор чанарын үнэлгээний хороо ба хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааны ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, уялдуулах;

**Шалгуурыг хангасан байдал: Шаардлагыг бүрэн хангасан.**

**7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2	1		4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
<b>Дүгнэлт</b>		Бүрэн хангасан			

Холбогдох тайлан, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Мандах их сургуулийн “Санхүү” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг санхүүгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг .....Б.МӨНХБАЯР

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг ..... Н.БАТДЭЛГЭР

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг ..... С.АЛТАНЦЭЦЭГ



## ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Санхүүгийн хөтөлбөрийн онцлог ялгарлыг оролцогч талуудын оролцоотой хамтран тодорхойлох, тодорхой харуулах;
2. Хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах зорилгоор оролцогч талуудын санал, хэрэгцээг тогтмол судлах;
3. Суралцагчдын мэдлэг чадварыг үнэлж байгаа арга туршлагаа улам боловсронгуй болгож, суралцахуйн хүрэх үр дүн (learning outcome)-д тулгуурлан хэрхэн үнэлж болохыг тодорхойлон хэрэгжүүлэх;
4. Цахим сургалтыг дэмжих дэд бүтцийн хүртээмж, өгөөжийг тооцох;
5. Ном сурах бичгийн ашиглалт, хүрэлцээ хангамжийн судалгаа, шинжилгээг тогтмолжуулах;
6. Сургалтын хөтөлбөрийн хороо болон тэнхимийн харилцан хамаарал, уялдааг сайжруулах;
7. Багшийн хөгжлийн иж бүрэн хөтөлбөрийг боловсруулж, түүний хэрэгжилтэд үнэлэлт өгдөг, сайжруулалт хийдэг арга зүйтэй байх;
8. Эрдэм шинжилгээний мэдээллийн сан ашиглалтын байдал болон багш судлаачдын бүтээлийг олон улсын нэр хүндтэй сэтгүүлд хүлээн зөвшөөрүүлэх ажилд тандалт судалгааг хийж сургуулийн ЭШ-ний тайланд тусгаж байх;
9. Бизнесийн төсөл ба захиалгат судалгааны төсөлд оролцох, эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээ олон улсын хянан магадалгаа хийгддэг сэтгүүлд хүлээн зөвшөөрүүлэх зэрэг ажилд багш нарын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах;
10. Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын үйл явцыг сайжруулах;
11. Хөтөлбөрийн чанарын болон үр нөлөөний үнэлгээ, чанарын баталгаажуулалтын үйл явцад оролцогч талуудын үүргийг нэмэгдүүлэхэд мэргэжлийн байгууллагуудын үнэлгээг ашиглах;

#### IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

##### I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	С. Цолмон	Дэд профессор	Доктор	10	Санхүүгийн удирдлага, Санхүүгийн эконометрикс, Зээлийн шинжилгээ
2	Ж. Гантулга	Багш	Магистр	6	Мэргэжлийн удиртгал Санхүүгийн үндэс, Банкны менежмент хяналт, шалгалт
3	Г. Эрдэнэцогт	Багш	Магистр	3	Мэргэжлийн удиртгал, Зээлийн шинжилгээ Санхүүгийн удирдлага
4	Г. Уянга	Багш	Магистр	2	Санхүүгийн үндэс, Санхүүгийн эрсдэлийн удирдлага

##### II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1.	С.Энхжин	Санхүү-2	2 болон 3-р курсийн мэргэжлийн ангийн оюутнуудаас лавлахад цар тахлаас шалтгаалан зарим нь ажилтай, зарим нь хөдөө орон нутаг руу гэртээ харьсан зэрэг шалтгааны улмаас ярилцлагад орох боломжгүй байсан учир тухайн ярилцлагыг онлайнаар саадгүй явуулахын тулд оролцох боломжтой оюутнуудыг санамсаргүй түүврийн байдлаар сонгосон
2.	Э.Ганчимэг	Санхүү-2	
3.	Б.Дөлгөөнбаяр	Санхүү-2	
4.	Э.Сарангоо	Санхүү-2	
5.	Б.Уянгаа	Санхүү-2	
6.	П.Энхманлай	Санхүү-2	
7.	Х.Гүлнур	Санхүү-2	
8.	Н.Өсөхбаяр	Санхүү-2	
9.	Г.Мөнгөн-Эрдэнэ	Санхүү-2	
10.	О.Номин	Санхүү-2	
11.	А.Мишээл	Санхүү-2	
12.	Ч.Мөнхбат	Санхүү-3	
13.	М.Гармаа	Санхүү-3	
14.	А.Ариунзаяа	Санхүү-3	
15.	Б.Идэрбат	Санхүү-3	
16.	Ж.Халиунаа	Санхүү-3	
17.	Б.Лхагвасүрэн	Санхүү-3	
18.	Х.Мөнхцэцэг	Санхүү-3	

### III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1.	н.Даваадулам	Төрийн банк	Метро молл салбарын захирал
2.	Э.Баасанбат	ХХБанк	Санхүү удирдлагын хэлтсийн дарга
3.	н.Энхчимэг	ХХБанк	Хүний нөөцийн менежер
4.	Д.Билгүүн	Голомт банк	Хүний нөөцийн удирдлагын газар- Үйл ажиллагааны хэлтсийн ахлах менежер
5.	н.Сарангэрэл	Транскапитал ББСБ	Хүний нөөцийн менежер
6.	н.Нинжбадгар	Инвескор ББСБ	Хүний нөөцийн газар хариуцсан менежер
7.	н.Алтангоо	Хасбанк	21-р хороолол тооцооны төвийн захирал
8.	н.Ганбат	Хаанбанк	Салбарын үйл ажиллагааны газрын захирал

### IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1.	Анударь	2020	Нет Капитал	Зээлийн мэргэжилтэн
2.	Есөнцагаан	2020	Хас банк	Харилцагчийн үйлчилгээний ажилтан
3.	Лхагвасүрэн	2020	Худалдаа хөгжлийн банк	Харилцагчийн үйлчилгээний ажилтан
4.	Намуун	2020	Мандах Их Сургууль	Оюутантай хариуцсан ажилтан
5.	Номин-Эрдэнэ	2020	Эрчэс хурд ХХК	Нягтлан
6.	Амгалан	2020	Голомт банк	Харилцагчийн үйлчилгээний ажилтан
7.	Болдмөнх	2020	Эрхэлсэн тодорхой ажилгүй	
8.	Лхагвасүрэн	2020	Голомт Капитал	Туслах Дилер
9.	Өнөрсан	2020	Төрийн банк	Харилцагчийн үйлчилгээний ажилтан
10.	Даваадулам	2019	Төрийн банк	Харилцагчийн үйлчилгээний ажилтан
11.	Лхагвасүрэн	2019	Голомт	Харилцагчийн үйлчилгээний ажилтан

## V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/



### МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

16040, Ш/Х:88, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг  
16-р хороо, Гандан, Амарсанаагийн гудамж 18/1  
Утас: 70185950, 70185949 Факс: (976) 70001183  
E-mail: info@mandakh.edu.mn, http://www.mandakh.edu.mn

Бор. 10.21 № 219  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г  
Г \_\_\_\_\_ Г

Г БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН Г  
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Шинжээчийн багийн тайлан хүлээн авсан тухай

Тус сургуулийн Санхүүгийн бакалаврын хөтөлбөрт магадлан итгэмжлэл хийлгэхээр БМИҮЗ-өөс томилсон Б.Мөнхбаяр ахлагчтай, Н.Батдэлгэр, С.Алтанцэцэг нарын бүрэлдэхүүнтэй шинжээчийн баг нь 2020 оны 05 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд Мандах Их Сургуулийн үйл ажиллагаа, нотлох баримттай танилцаж ажилласан болно.

Шинжээчдийн багийн тайланг хүлээн авч, танилцлаа. Уг тайланд тусгагдсан шинжээчдийн өгсөн зөвлөмж, анхаарах асуудлыг цаашид үйл ажиллагаандаа тусган ажиллах болно.

ЗАХИРАЛ



Г.НАНЖИД

## ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) .....  
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**

## ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)  
..... [Магадлан итгэмжлэх комиссын  
хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**